



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: teqshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: М.Мөнхтөгс
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/235
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ө.ОТГОНГЭРЭЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур сумын Эрүүл Мэндийн Төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цагааннуур сумын Эрүүл Мэндийн Төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар аж ахуй, шатахуун, бичиг хэргийн материалын зарцуулалтын зардалд нярвын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, бараа материал, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгээгүй нь тайлант хугацааны эцэс дэх бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл, түүний хөдөлгөөнийг хянан баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлийн 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 28.0 хувиар өссөн байна.

5724040554

Аудитын гол асуудал

Төсвийн зарцуулалттай холбоотой албан томилолтоор ажилласан 4 албан хаагчдын томилолтын зардал 390.0 мянган төгрөгийг илүү олгосон, цалингийн сангаас 12,885.3 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын тайланг, 178,988.7 мянган төгрөгөөр хувь хүний орлогын албан татварын тайланг тус тус зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын дарга нь 2023 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө Сумын засаг даргаар 9 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулж, 92 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>147,512,253.99</u>	<u>101,825,726.83</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	23,771,346.67	8,423,097.86
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	23,771,346.67	8,423,097.86
3121	Төгрөг	23,771,346.67	8,423,097.86
31211	Төрийн сангийн харилцах	23,771,346.67	8,423,097.86
33	АВЛАГА	5,502.00	-
335	Бусад авлага	5,502.00	-
3351	Байгууллагаас авах авлага	5,502.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	123,735,405.32	93,402,628.97
351	Түүхий эд материал	55,512,759.96	32,188,965.52
35130	Эм боох материал	55,512,759.96	32,188,965.52
354	Хангамжийн материал	68,222,645.36	61,213,663.45
35410	Бичиг хэргийн материал	4,097,300.00	1,229,950.00
35420	Аж ахуйн материал	13,469,501.47	15,507,209.33
35430	Сэлбэг хэрэгсэл	5,065,500.00	401,750.00
35440	Түлш, шатах тослох материал	11,876,560.77	8,507,242.60
35450	Барилгын засварын материал	8,195,700.00	8,195,700.00
35460	Хүнсний материал	2,470,052.00	589,687.40
35470	Бусад хангамжийн материал	23,048,031.12	26,782,124.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>436,805,271.05</u>	<u>390,772,503.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	436,805,271.05	390,772,503.50
392	Биет хөрөнгө	417,671,270.97	371,678,503.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	296,226,943.82	296,226,943.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	-65,283,417.06	(77,972,614.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,112,533.00	103,112,533.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,989,147.67	(65,926,254.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	220,895,209.00	247,441,733.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-100,853,484.07	(139,656,096.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,267,200.00	15,152,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,869,066.09	(6,699,941.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,529,000.00	1,529,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,364,499.96	(1,529,000.00)
393	Биет бус хөрөнгө	19,134,000.08	19,094,000.12
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-79,999.92	(119,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,814,000.00	18,814,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>584,317,525.04</u>	<u>492,598,230.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>18,164,075.79</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	18,164,075.79
413	Өглөг	00.00	18,164,075.79
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	4,296,741.95

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	1,797,241.14
4136	Бусад өглөг	00.00	12,070,092.70
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	12,070,092.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>584,317,525.04</u>	<u>474,434,154.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	584,317,525.04	474,434,154.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,519,675.00	265,519,675.00
51101	Өмч: - төрийн	265,519,675.00	265,519,675.00
512	Хуримтлагдсан үр дүн	254,859,252.54	144,975,882.04
51210	Өмнөх үеийн үр дүн	254,859,252.54	254,859,252.54
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(109,883,370.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,938,597.50	63,938,597.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>584,317,525.04</u>	<u>492,598,230.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	549,998,477.09	612,784,737.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,186,217.09	38,869,285.37
120	Нийтлэг татварын бус орлого	66,186,217.09	38,869,285.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,186,217.09	38,869,285.37
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	66,186,217.09	38,869,285.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	483,812,260.00	573,915,451.98
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,019,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,019,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,683,800.00	36,250,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,683,800.00	36,250,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	438,109,460.00	537,665,451.98
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	438,109,460.00	537,665,451.98
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	596,293,369.33	722,668,107.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	596,293,369.33	722,668,107.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	596,237,346.60	722,665,440.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,024,045.61	416,013,551.10
210101	Үндсэн цалин	234,974,300.20	282,018,288.98
210102	Нэмэгдэл	65,804,746.41	78,402,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,715,000.00	4,559,129.35
210104	Урамшуулал	20,944,709.00	51,034,132.77
210105	Гэрээт ажлын хөлс	585,290.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,046,621.21	51,920,113.23
210201	Тэтгэврийн даатгал	19,604,194.31	26,192,830.24
210202	Тэтгэмжийн даатгал	3,003,133.29	16,579,061.69

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,402,506.64	2,312,685.67
210204	Ажилгүйдлийн даатгал	548,798.82	1,294,821.44
210205	Эрүүл мэндийн даатгал	5,487,988.15	5,540,714.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,239,760.98	33,653,420.00
210301	Гэрэл, цахилгаан	1,444,034.27	4,077,213.01
210302	Түлш, халаалт	24,795,726.71	29,576,206.99
2104	Хангамж, бараа материалын зардал	41,897,983.23	43,805,268.37
210401	Бичиг хэрэг	3,392,800.00	11,506,002.00
210402	Тээвэр, шатахуун	33,679,183.23	28,527,859.37
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,350,000.00	2,420,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	976,000.00	1,343,007.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	8,400.00
2105	Нормативт зардал	85,097,809.96	81,234,564.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,054,430.96	66,712,250.37
210502	Хоол, хүнс	13,407,379.00	14,522,314.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	636,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,935,875.00	16,415,552.14
210604	Урсгал засвар	6,935,875.00	16,415,552.14
2107	Томилолт, зочны зардал	3,295,000.00	2,930,999.00
210702	Дотоод албан томилолт	3,295,000.00	2,930,999.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,389,880.00	2,082,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,290,000.00	80,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,872,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	130,680.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,099,880.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,310,370.61	74,609,292.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,743,500.00	145,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,566,870.61	74,464,292.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,022.73	2,666.99
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,022.73	2,666.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-46,294,892.24</u>	<u>-109,883,370.50</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-46,294,892.24</u>	<u>-109,883,370.50</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>505,474,060.00</u>	<u>584,699,544.68</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>21,661,800.00</u>	-
120	Нийтлэг татварын бус орлого	21,661,800.00	-

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,661,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,661,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	483,812,260.00	584,699,544.68
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,019,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,019,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,683,800.00	36,250,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,683,800.00	36,250,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	438,109,460.00	548,449,544.68
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	438,109,460.00	548,449,544.68
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	495,217,426.90	591,162,793.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,217,426.90	591,162,793.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	495,161,404.17	591,160,126.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,954,618.89	406,014,242.36
210101	Үндсэн цалин	215,180,665.74	264,757,460.80
210102	Нэмэгдэл	74,554,697.46	80,423,442.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,225,000.00	9,743,216.73
210104	Урамшуулал	25,927,099.00	51,090,122.26
210105	Гэрээт ажлын хөлс	4,067,156.69	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,046,621.21	56,295,160.02
210201	Тэтгэврийн даатгал	20,110,769.86	38,678,603.46
210202	Тэтгэмжийн даатгал	3,012,911.63	4,379,032.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,268,656.77	3,329,479.48
210204	Ажилгүйдлийн даатгал	552,199.99	921,723.42
210205	Эрүүл мэндийн даатгал	5,102,082.96	8,986,320.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,520,734.27	32,747,333.01
210301	Гэрэл, цахилгаан	1,444,034.27	3,749,114.95
210302	Түлш, халаалт	26,576,200.00	27,499,120.00
210303	Цэвэр, бохир ус	500,500.00	1,499,098.06
2104	Хангамж, бараа материалын зардал	39,767,200.00	28,934,328.20
210401	Бичиг хэрэг	2,021,000.00	944,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,925,950.00	23,845,328.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,747,750.00	2,420,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,208,900.00	1,125,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,863,600.00	600,000.00
2105	Нормативт зардал	46,711,679.80	42,634,913.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,208,379.80	25,544,863.92
210502	Хоол, хүнс	14,543,300.00	13,092,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,960,000.00	3,998,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,451,600.00	11,644,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	10,451,600.00	9,644,800.00

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	3,295,000.00	2,930,999.00
210702	Дотоод албан томилолт	3,295,000.00	2,930,999.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,862,150.00	3,148,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,328,550.00	80,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,872,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	130,680.00
210807	Газрын төлбөр	-	41,520.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	533,600.00	1,024,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,551,800.00	6,809,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,551,800.00	6,809,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,022.73	2,666.99
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	56,022.73	2,666.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,256,633.10</u>	<u>(6,463,248.82)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	8,885,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,885,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,885,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(8,885,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,256,633.10	(15,348,248.82)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,514,713.57	23,771,346.67
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,771,346.67	8,423,097.86

2.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	246,705,675.00	31,180,030.07	(57,609,428.93)	220,276,276.14
Тайлант үеийн үр дүн	-	-	6,240,278.71	6,240,278.71
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,519,675.00	63,938,597.50	254,859,252.54	584,317,525.04
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,519,675.00	63,938,597.50	254,859,252.54	584,317,525.04
Тайлант үеийн үр дүн	-	-	(109,883,370.50)	(109,883,370.50)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,519,675.00	63,938,597.50	144,975,882.04	474,434,154.54

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	645,384,200.00	600,506,273.50	44,877,926.50	93%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	645,384,200.00	600,506,273.50	44,877,926.50	93%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	645,384,200.00	600,506,273.50	44,877,926.50	93%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,267,200.00	412,966,122.36	26,301,077.64	94%
210101	Үндсэн цалин	289,041,400.00	271,709,340.80	17,332,059.20	94%
210102	Нэмэгдэл	99,101,300.00	80,423,442.57	18,677,857.43	81%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,500,000.00	9,743,216.73	(5,243,216.73)	217%
210104	Урамшуулал	46,624,500.00	51,090,122.26	(4,465,622.26)	110%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,617,800.00	56,295,160.02	2,322,639.98	96%
210201	Тэтгэврийн даатгал	39,860,000.00	38,678,603.46	1,181,396.54	97%
210202	Тэтгэмжийн даатгал	4,689,500.00	4,379,032.97	310,467.03	93%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,751,200.00	3,329,479.48	421,720.52	89%
210204	Ажилгүйдлийн даатгал	938,300.00	921,723.42	16,576.58	98%
210205	Эрүүл мэндийн даатгал	9,378,800.00	8,986,320.69	392,479.31	96%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,750,000.00	32,750,000.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	3,750,000.00	3,750,000.00	-	100%
210302	Түлш, халаалт	27,500,000.00	27,500,000.00	-	100%
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	30,145,700.00	30,144,328.20	1,371.80	100%
210401	Бичиг хэрэг	1,125,000.00	944,000.00	181,000.00	84%
210402	Тээвэр, шатахуун	23,465,700.00	23,845,328.20	(379,628.20)	102%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,000.00	2,420,000.00	10,000.00	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,125,000.00	1,125,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,810,000.00	190,000.00	91%
2105	Нормативт зардал	45,618,700.00	42,634,913.92	2,983,786.08	93%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,502,000.00	25,544,863.92	2,957,136.08	90%
210502	Хоол, хүнс	13,116,700.00	13,092,050.00	24,650.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	3,998,000.00	2,000.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,500,000.00	19,319,800.00	3,180,200.00	86%
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00	-	100%
210604	Урсгал засвар	13,500,000.00	10,319,800.00	3,180,200.00	76%
2107	Томилолт, зочны зардал	2,999,700.00	2,930,999.00	68,701.00	98%

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	2,999,700.00	2,930,999.00	68,701.00	98%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,696,700.00	3,148,950.00	1,547,750.00	67%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	749,700.00	80,000.00	669,700.00	11%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,872,000.00	1,872,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	-	100,000.00	0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	130,680.00	69,320.00	65%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	-	150,000.00	0%
210807	Газрын төлбөр	500,000.00	41,520.00	458,480.00	8%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,125,000.00	1,024,750.00	100,250.00	91%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,788,400.00	316,000.00	8,472,400.00	4%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,788,400.00	316,000.00	8,472,400.00	4%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	645,384,200.00	584,699,544.68	60,684,655.32	91%
132001	Орон нутгийн төсвөөс	36,250,000.00	36,250,000.00	-	100%
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	575,362,900.00	548,449,544.68	26,913,355.32	95%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	575,362,900.00	548,449,544.68	26,913,355.32	95%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	33,771,300.00	-	33,771,300.00	0%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	-	10,000,000.00	0%
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	23,771,300.00	-	23,771,300.00	0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	23,771,346.67		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,423,097.86		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	-	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100%
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	22.00	-	100%
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	14.00	14.00	-	100%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00	-	100%
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100%

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 351,793.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 35,262.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 390.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, бараа материалын данстай холбоотой 1 албан шаардлага, 316,141.6 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 16,322.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 9,540.7 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 33,464.9 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд бүртгээгүй байсныг;
- Санхүүгийн тайланд тусгагдсан эмийн өглөгтэй холбоотой тооцоолол, тооцоо нийлсэн акттай тохирохгүй 1,797.2 мянган төгрөгийн зөрүүтэй байсныг тайлангийн хугацаанд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Томилолтын зардал 4 хүнд 390.0 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ”, 2.2.1. “унааны зардал”; 2.2.2. “байрны зардал”; 2.2.3. “хоолны зардал”; НББ-ийн тухай хууль 5.1.4 үнэн зөв байх гэсэн заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Аж ахуй, шатахуун, бичиг хэргийн материалын зарцуулалтын зардалд нярвын анхан шатны баримтын бүрдэл байхгүй, жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1. “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлийн 70.2.2-т “*түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1- / гэсэн заалт, Оршин байх батламж мэдэгдэл хангахгүй тул албан шаардлага хүргүүлэв.*

5.3 Зөвлөмж

1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайлангаас 12,885.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” 17.1.3 “Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг үнэн зөв тооцоолж, Нийгмийн даатгалын тайланд залруулга хийх, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Татварын тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Хувь хүний орлогын албан татварын тайланг 178,988.7 мянган төгрөгийн зөрүүтэй илгээсэн нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", ХХОАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого гэсэн заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг үндэслэн Хувь хүний орлогын албан татварын тайланг үнэн зөв гаргаж залруулга хийх, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

4. Шилэн данстай холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсыг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 121,220.9 мянган төгрөгийн орлого зарлагын мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийг бүрэн байршуулах, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМГ-аас ирсэн үнэ төлбөргүй бараа материалыг орлогод аваагүй	1	33,464.9			1	33,464.9	1	33,464.9		
Санхүүгийн тайланд тусгагдсан эмийн өглөгтэй холбоотой тооцоолол, тооцоо нийлсэн акттай тохирохгүй 1,797.2 мянган төгрөгийн зөрүүтэй	1	1,797.2			1	1,797.2	1	1,797.2		
Дүн	2	35,262.1			2	35,262.1	2	35,262.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолтын тооцоог мөнгөн хөрөнгийн анхан шатны баримттай тулгахад, 4 хүнд томилолтын зардал 390.0 мянган төгрөг илүү олгосон байна	1	390.0	1	390.0				
Аж ахуй, шатахуун, бичиг хэргийн материалын зарцуулалтын зардалд няравын анхан шатны баримтын бүрдэл байхгүй, жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй байна.	1	-			1	-		
Цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайлангаас 12,885.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	12,885.3					1	12,885.3
12-р сарын цалинг Нийгмийн даатгалын тайланд 12,885.3 төгрөгөөр дутуу тайлагнаснаас НДШ-ийн өглөг 3,046.7 төгрөгөөр үүссэнийг бүртгээгүй байна	1	3,046.7					1	3,046.7
Хувь хүний орлогын албан	1	178,988.					1	178,988.7

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

татварын тайланг 178,988.7 мянган төгрөгийн зөрүүтэй илгээсэн байна.		7						
Дүн	5	195,310.7	1	390.0	1	-	3	194,920.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг байршуулаагүй.	1	121,220.9					1	121,220.9
Нийт дүн	1	121,220.9					1	121,220.9

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1					1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1					1		



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 58/2024/ХАА-0024/44
НА-БТА-ТМЭ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтын зардал олгохдоо 4 хүнд 390,000.0 /гурван зуун ерэн мянга/ төгрөг илүү олгосон.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4-т “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно.” гэж заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 390,000.0 /гурван зуун ерэн мянга/ төгрөгийн томилолтын зардлыг буцаан төлүүлж Хөвсгөл аймгийн Төрийн сангийн 10170000955 /Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх; ;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ө.Отгонгэрэл, нягтлан бодогч Г.Цэцэгмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724020204



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 33/А2270439/ХӨА-2024/
44/АА-С/11 А-111ШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуй, шатахуун, бичиг хэргийн материалын зарцуулалтын зардалд нярвын анхан шатны баримтын бүрдэл байхгүй, жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа” гэж заасныг тус тус зөрчсөн ба оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ гаргасан, бараа материал, үндсэн хөрөнгө тооллого явуулаагүй зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ө.Отгонгэрэл, нягтлан бодогч Г.Цэцэгмаа нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724020131